



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/114/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд суданга,
3 дугаар баг, Сайвшивил сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цалин хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 16/164

танай _____-ны № _____-т

УЛААНБАДРАХ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.НАМЖИЛСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад мөнгөн хөрөнгийн дансанд их хэмжээний өөрчлөлт орсон байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах,

01000948

санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 59.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 842.2 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 504.6 сая төгрөгийн 19 гүйлгээ, 0.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 280.4 сая төгрөгийн зарлагын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20.7 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 9 харилцагчдаас 2.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тоног төхөөрөмж болон номын үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 10 зорилт, 45 арга хэмжээний хэрэгжилт 97.5 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 91.5 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	113,717,082.79	154,815,793.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	59,110,347.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	59,110,347.00
3121	Төгрөг	-	59,110,347.00
31211	Төрийн сангийн харилцах	-	49,302,977.00
31212	Монгол банкин дахь харилцах	-	9,807,370.00
33	АВЛАГА	45,504,587.00	17,346,070.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	45,504,587.00	17,346,070.00
35	БАРАА МАТЕРИАЛ	68,212,495.79	78,359,376.19
351	Түүхий эд материал	18,887,159.56	23,639,851.96
35110	Тусгай зориулалттай материал	18,247,039.56	23,435,751.96
35130	Эм боох материал	640,120.00	204,100.00
354	Хангамжийн материал	49,325,336.23	54,719,524.23
35410	Бичиг хэргийн материал	2,047,047.00	1,524,847.00
35420	Аж ахуйн материал	5,888,727.50	8,460,617.50
35440	Түлш, шатах тослох материал	1,530,600.03	504,000.03
35460	Хүнсний материал	2,986,502.00	4,414,775.00
35470	Бусад хангамжийн материал	36,872,459.70	39,815,284.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,312,110,164.00	1,365,727,591.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,312,110,164.00	1,365,727,591.24
392	Биет хөрөнгө	1,310,190,747.20	1,364,239,924.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,279,077,303.00	1,279,077,303.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(88,491,518.04)	(124,813,238.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,500,000.00	21,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,500,000.00)	(21,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	130,082,680.17	134,281,544.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(95,621,879.24)	(36,607,124.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,691,119.42	109,687,073.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(65,668,379.93)	(43,038,704.41)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,573,512.00	52,095,378.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,780,304.29)	(14,118,863.13)
39217	Ном	12,328,214.11	7,676,556.00
393	Биет бус хөрөнгө	1,919,416.80	1,487,666.88
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(719,583.20)	(1,151,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	912,000.00	912,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,425,827,246.79	1,520,543,384.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	682,695.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	682,695.00
413	Өглөг	-	682,695.00
4136	Бусад өглөг	-	682,695.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	461,170.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	221,525.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,425,827,246.79	1,519,860,689.43
51	Засгийн газрын хувь оролцоо	1,425,827,246.79	1,519,860,689.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	926,586,877.86	926,586,877.86
51101	Өмч: - төрийн	926,586,877.86	926,586,877.86
512	Хуримтлагдсан үр дүн	157,096,042.22	253,462,768.34
51210	Өмнөх үеийн үр дүн	200,848,208.50	161,476,695.70
51220	Тайлант үеийн үр дүн	(43,752,166.28)	91,986,072.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	342,144,326.71	339,811,043.23
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,425,827,246.79	1,520,543,384.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	550,276,092.90	797,818,769.49
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,879,663.90	119,607,212.37
120	Нийтлэг татварын бус орлого	34,879,663.90	119,607,212.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,088,071.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,088,071.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	30,051,474.00	115,234,029.97
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	3,740,118.90	4,373,182.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	515,396,429.00	678,211,557.12

1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,304,700.00	548,913,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	548,913,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,304,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,684,470.00	1,077,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,684,470.00	1,077,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,407,259.00	128,220,257.12
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	98,407,259.00	128,220,257.12
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	594,214,588.54	700,777,255.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,214,588.54	700,777,255.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	579,805,213.15	656,945,555.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	339,350,387.61	381,812,930.00
210101	Үндсэн цалин	213,749,295.00	283,186,069.00
210102	Нэмэгдэл	93,755,549.00	89,599,538.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,700,000.00	-
210104	Урамшуулал	25,145,543.61	9,027,323.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,289,100.00	49,048,271.00
210201	Тэтгэврийн даатгал	30,229,700.00	33,795,665.78
210202	Тэтгэмжийн даатгал	3,302,100.00	3,826,210.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,641,600.00	3,060,967.71
210204	Ажилгүйдлийн даатгал	646,900.00	758,622.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,468,800.00	7,606,805.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,613,359.00	98,544,811.12
210301	Гэрэл, цахилгаан	3,841,689.00	6,708,131.12
210302	Түлш, халаалт	91,983,480.00	90,895,280.00
210303	Цэвэр, бохир ус	788,190.00	941,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,664,699.59	9,212,635.00
210401	Бичиг хэрэг	3,565,148.00	1,011,200.00
210402	Тээвэр, шатахуун	2,441,692.00	2,484,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	-
210404	Ном, хэвлэл	869,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	199,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,902,250.00	982,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,309,400.00	960,000.00
210408	Бараа материал акталсны зардал	8,278,209.59	3,773,995.00
2105	Нормативт зардал	17,562,710.60	30,322,727.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,022,620.00	436,020.00
210502	Хоол, хүнс	16,540,090.60	29,886,707.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,695,750.03	181,600.04
210602	Тавилга	109,950.03	146,600.04
210604	Урсгал засвар	3,585,800.00	35,000.00
2107	Томилолт, зочны зардал	480,000.00	-
210702	Дотоод албан томилолт	480,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,554,450.00	2,897,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,122,450.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,897,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,594,756.32	84,925,580.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	233,100.00	11,020,050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	59,080.00	3,921,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,302,576.32	69,983,580.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,409,375.39	43,831,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,850,700.00	43,831,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,516,200.00	30,316,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,334,500.00	13,515,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,000.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,533,675.39	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,533,675.39	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(43,938,495.64)	97,041,514.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,999.64	37,550.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	34,999.64	37,550.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(34,999.64)	(5,055,441.74)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(43,973,495.28)	91,986,072.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	516,484,500.00	680,996,927.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,088,071.00	3,862,870.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,088,071.00	3,862,870.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,088,071.00	3,862,870.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,077,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,088,071.00	738,000.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		2,047,370.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	515,396,429.00	677,134,057.12
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,304,700.00	548,913,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	548,913,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	409,304,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,684,470.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,684,470.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	98,407,259.00	128,220,257.12
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	98,407,259.00	128,220,257.12
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	506,485,282.00	608,167,560.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,485,282.00	608,167,560.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,771,906.61	566,757,260.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,119,297.61	353,654,413.00
210101	Үндсэн цалин	191,518,205.00	261,656,528.00
210102	Нэмэгдэл	93,755,549.00	83,070,562.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,700,000.00	-
210104	Урамшуулал	25,145,543.61	8,927,323.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,289,100.00	49,048,271.00
210201	Тэтгэврийн даатгал	30,229,700.00	33,795,665.78
210202	Тэтгэмжийн даатгал	3,302,100.00	3,826,210.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,641,600.00	3,060,967.71
210204	Ажилгүйдлийн даатгал	646,900.00	758,622.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,468,800.00	7,606,805.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,423,759.00	98,538,411.12
210301	Гэрэл, цахилгаан	3,841,689.00	6,708,131.12
210302	Түлш, халаалт	90,895,980.00	90,895,280.00
210303	Цэвэр, бохир ус	686,090.00	935,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,702,000.00	-
210401	Бичиг хэрэг	2,787,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,600,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	-
210404	Ном, хэвлэл	965,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	205,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,045,000.00	-
2105	Нормативт зардал	18,804,700.00	33,666,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	245,000.00	-
210502	Хоол, хүнс	17,789,700.00	33,666,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	770,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,558,500.00	4,990,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	575,000.00	-
210604	Урсгал засвар	2,983,500.00	4,990,600.00
2107	Томилолт, зочны зардал	480,000.00	-
210702	Дотоод албан томилолт	480,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,559,550.00	3,635,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,127,550.00	738,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2,897,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,835,000.00	23,224,515.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	16,604,215.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,835,000.00	6,620,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,713,375.39	41,410,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,154,700.00	41,410,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,516,200.00	27,895,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,638,500.00	13,515,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,000.00	-

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,533,675.39	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,533,675.39	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,999,218.00	72,829,367.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,911,147.00	13,719,020.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,911,147.00	13,719,020.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,911,147.00	13,719,020.00
222001	Тоног төхөөрөмж	-	13,719,020.00
223001	Бусад хөрөнгө	8,911,147.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(8,911,147.00)	(13,719,020.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,088,071.00	59,110,347.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	59,110,347.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	926,586,877.86	342,144,326.71	200,848,208.50	1,469,579,413.07
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	926,586,877.86	342,144,326.71	200,848,208.50	1,469,579,413.07
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,752,166.28)	(43,752,166.28)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	926,586,877.86	342,144,326.71	157,096,042.22	1,425,827,246.79
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	926,586,877.86	342,144,326.71	157,096,042.22	1,425,827,246.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,380,653.48	4,380,653.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	926,586,877.86	342,144,326.71	161,476,695.70	1,430,207,900.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(2,333,283.48)	-	(2,333,283.48)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	91,986,072.64	91,986,072.64
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	926,586,877.86	339,811,043.23	253,462,768.34	1,519,860,689.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	679,446,200.00	621,886,580.12	57,559,619.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	679,446,200.00	621,886,580.12	57,559,619.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	633,794,600.00	580,476,280.12	53,318,319.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	405,737,800.00	353,654,413.00	52,083,387.00
210101	Үндсэн цалин	309,844,800.00	261,656,528.00	48,188,272.00
210102	Нэмэгдэл	86,200,100.00	83,070,562.00	3,129,538.00
210104	Урамшуулал	9,692,900.00	8,927,323.00	765,577.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,881,500.00	49,048,271.00	1,833,229.00
210201	Тэтгэврийн даатгал	34,599,500.00	33,795,665.78	803,834.22
210202	Тэтгэмжийн даатгал	4,070,500.00	3,826,210.22	244,289.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,256,400.00	3,060,967.71	195,432.29
210204	Ажилгүйдлийн даатгал	814,000.00	758,622.02	55,377.98
210205	Эрүүл мэндийн даатгал	8,141,100.00	7,606,805.27	534,294.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,050,500.00	98,538,411.12	512,088.88
210301	Гэрэл, цахилгаан	7,134,600.00	6,708,131.12	426,468.88
210302	Түлш, халаалт	90,895,900.00	90,895,280.00	620.00
210303	Цэвэр, бохир ус	1,020,000.00	935,000.00	85,000.00
2105	Нормативт зардал	30,154,300.00	33,666,050.00	(3,511,750.00)
210502	Хоол, хүнс	30,154,300.00	33,666,050.00	(3,511,750.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,990,600.00	9,400.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,990,600.00	9,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,151,500.00	3,635,000.00	1,516,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	738,000.00	738,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,413,500.00	2,897,000.00	1,516,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,819,000.00	36,943,535.00	875,465.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,198,700.00	30,323,235.00	875,465.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,620,300.00	6,620,300.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,651,600.00	41,410,300.00	4,241,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,651,600.00	41,410,300.00	4,241,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,176,400.00	27,895,100.00	6,281,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,475,200.00	13,515,200.00	(2,040,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	679,446,200.00	680,996,927.12	(1,550,727.12)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	550,704,300.00	549,991,300.00	713,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	550,704,300.00	548,913,800.00	1,790,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,077,500.00	(1,077,500.00)
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,741,900.00	128,220,257.12	521,642.88
132001	Орон нутгийн төсвөөс	128,741,900.00	128,220,257.12	521,642.88
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,785,370.00	(2,785,370.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	738,000.00	(738,000.00)
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө		2,047,370.00	(2,047,370.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		59,110,347.00	(59,110,347.00)
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29.00	29.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-
620003	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	226.00	226.00	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	226.00	226.00	-
630001	Терийн өмчит ЕБС	226.00	226.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	29.00	29.00	-
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00	-
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6.0 сая төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад 6.0 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Дахин үнэлгээний нэмэгдлийг 2.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг залруулсан.
2. Цалингийн зардалд бараа материалын 0.5 сая төгрөг бүртгэснийг залруулсан.
3. Түлш халаалтын зардалд 0.3 сая төгрөгийн А80 бензин бүртгэснийг, урсгал засварын зардалд 0.1 сая төгрөгийн элэгдлийн зардал бүртгэснийг залруулсан.
4. Түрээсийн сурах бичгийн 0.7 сая төгрөгийг үр дүнгийн тайланд зардлаар бүртгэснийг залруулсан.
5. Өмнөх оны аудитлагдсан тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан.

Аудитаар нийт 4 зөрчил² илэрснээс, 1 зөвлөмж, 2 албан шаардлага, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчил тайлант онд давтагдсан тул 1 хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 842.2 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 504.6 сая төгрөгийн 19 гүйлгээ, 0.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 280.4 сая төгрөгийн зарлагын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20.7 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өмнөх оны аудитаар илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил нь тайланд онд давтагдсан тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Анхан шатны баримтын тулгалтаар 9 харилцагчдаас 2.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Тус байгууллага нь 2022 оны жилийн санхүүгийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны 07 тоотор ирүүлж, хугацаа хоцроосон. Энэ нь хэрэглэгчид үнэн зөв мэдээллээр хангагдаж чадахгүй байх, хууль хэрэгжихгүй байх үр дагавартай.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “...жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж”, Төрийн аудитын тухай хуулийн 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; гэсэн заалтад нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Тооллогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тоног төхөөрөмж болон номын үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Тооллого хийж дууссан огноогоор тооллогын үр дүнг тооцдоггүй, тайлант оны жилийн эцсийн үлдэгдлээр шууд тусгадагтай холбоотой байна. Энэ нь хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д заасан “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг бодитой, чанартай хийж, тооллогын үр дүнгээр холбогдох мэдээллүүдийг тодорхой тусгаж, акт үйлдэж, хариуцлага тооцож ажиллах.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дахин үнэлгээний нэмэгдлийг 2.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг залруулсан.	1	2,333.3			1	2,333.3	1	2,333.3				
Цалингийн зардалд бараа материалын 0.5 сая төгрөг бүртгэснийг залруулсан.	1	459.1			1	459.1	1	459.1				
Түлш халаалтын зардалд 0.3 сая төгрөгийн А80 бензин бүртгэснийг, урсгал засварын зардалд 0.1 сая төгрөгийн элэгдлийн зардал бүртгэснийг залруулсан.	1	427.1			1	427.1	1	427.1				
Түрээсийн сурах бичгийн 0.7 сая төгрөгийг үр дүнгийн тайланд зардлаар бүртгэснийг залруулсан.	1	738.0			1	738.0	1	738.0				
Өмнөх оны аудитлагдсан тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг залруулсан	1	2,047.4			1	2,047.4	1	2,047.4				
Дүн	5	6,005.1			5	6,005.1	5	6,005.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын тулгалтаар 9 харилцагчдаас 2.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1	-			1				-	-	-	
Тооллого хийсэн баримтаас тооцоо бодсон актын үр дүнтэй тулган бүртгэлээрх эцсийн үлдэгдэл рүү хөөн шалгахад тоног төхөөрөмж болон номын үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	1	301.5					1	301.5	-	-		
Тус байгууллага нь 2022 оны жилийн санхүүгийн тайланг 2023 оны 01 дүгээр сарын 26-ны 07 тоотой ирүүлж, хугацаа хоцроосон.	1	-			1							
Дүн	3	301.5			2		1	301.5			-	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 842.2 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 504.6 сая төгрөгийн 19 гүйлгээ, 0.4 сая төгрөгийн төсөв, хөрөнгө зарцуулах 1 шийдвэрийг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 280.4 сая төгрөгийн зарлагын 9 гүйлгээ, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 20.7 сая төгрөгийн зарлагын 3 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 10.2 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1				-	-	1	-	
Дүн	1				-	-	1	-	